**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 15 өдөр | Дугаар А/351 | Булган сум

Эрх шилжүүлж, ажил гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн Газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн тогтоох тухай” 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хуралдааны II/03 дугаар тогтоолоор баталсан Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг, ”Эрдэнэт Үйлдвэр” Төрийн Өмчит Үйлдвэрийн газрын 2024 оны хамтран ажиллах гэрээнд тусгагдсан төсөл арга хэмжээнээс хавсралтад заагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрхийг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир), Хангал сумын Засаг дарга (М.Төмөрбат), Бугат сумын Засаг дарга (Х.Ууганбаяр), Сайхан сумын Засаг дарга (Д.Сансар-Очир) нарт тус тус шилжүүлсүгэй.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 15-ны/ний өдрийн А/351 дугаар
захирамжийн хавсралт

БУЛГАН АЙМАГ, "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ-ЫН
2024 ОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗААЛТ

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Санхүүжилт /Сая, төг/ | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| *Нэг. Байгаль орчин, экологийн чиглэлээр:* | | | | | | |
| 1 | Экологийн боловсрол олгох зорилгоор “Хөдөлмөр” хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх (Хутаг-Өндөр сум) | Жилдээ | ХГБХХГ | Булган аймгийн ЗДТГ | 50.0 | “Хөдөлмөр” хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлж, сурагчдад байгаль орчныг хамгаалах экологийн боловсрол олгогдсон байна. |
| 2 | Байгаль орчны менежментийг сайжруулах (Хутаг-Өндөр сум) | Жилдээ | Сумын ЗДТГ, БОАЖГ | Булган аймгийн АЗДТГ | 30.0 | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын жуулчдын байгальд орчинд ээлтэй аялах боломж бүрдсэн байна. |
| 3 | Байгаль орчны менежментийг сайжруулах (Хангал сум) | Жилдээ | Сумын ЗДТГ, БОАЖГ | Булган аймгийн АЗДТГ | 30.0 | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын жуулчдын байгальд орчинд ээлтэй аялах боломж бүрдсэн байна. |
| 4 | Байгаль орчны менежментийг сайжруулах (Бугат сум) | Жилдээ | Сумын ЗДТГ, БОАЖГ | Булган аймгийн АЗДТГ | 30.0 | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын жуулчдын байгальд орчинд ээлтэй аялах боломж бүрдсэн байна. |
| 5 | Байгаль орчны менежментийг сайжруулах (Сайхан сум) | Жилдээ | Сумын ЗДТГ, БОАЖГ | Булган аймгийн АЗДТГ | 30.0 | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын жуулчдын байгальд орчинд ээлтэй аялах боломж бүрдсэн байна. |